

ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
БҮХИЙ ТАЛБАЙД ГҮЙЦЭТГЭХ “ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ”- Г
ХҮЛЭЭН АВАХ ДОТООД ЗААВАР

Цөмийн материалын хэлтсийн төлөвлөгөө хүлээн авах мэргэжилтэн нь Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4.4-д заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 30 хоногийн дотор ирүүлсэн хайгуулын ажлын төлөвлөгөөг дор дурдсан шаардлагыг хангуулан хүлээн авна. Үүнд:

1. Геологи хайгуулын ажлын төлөвлөгөөг тусгай зөвшөөрлийн талбай тус бүрээр монгол хэл дээр албан бичиг, төлөвлөгөө, тайлан, гэрээ боловсруулах стандарт /Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс баталсан “Зохион байгуулалт-захирамжлалын баримт бичиг”/-ын дагуу бичсэн байна.

2. Геологи хайгуулын ажлын төлөвлөгөөнд Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон түүний хавсралтуудын хуулбарыг хавсаргасан байна.

3. Геологи хайгуулын ажлын төлөвлөгөөг 1 жилийн хугацаагаар боловсруулж, гүйцэтгэх ажлын төрөл, хэмжээ, зардлыг тооцсон байна.

4. Геологи хайгуулын ажлын төлөвлөгөө нь Ерөнхий бүлэг, Геологийн тогтоц ба ашигт малтмал, Эрэл, хайгуулын ажлын аргачлал, Төсвийн тооцоо гэсэн үндсэн бүлгүүд, холбогдох хавсралт зургуудаас бүрдэнэ.

Ерөнхий бүлэг-т талбайн байршил, өмнө нь хийсэн геологийн судалгааны болон эрэл хайгуулын ажлын тухай, хайгуулын ажил хийхээр уг талбайг сонгосон үндэслэл, ажлын зорилго, ажиллах хүч, техник хангамж, ажил гүйцэтгэх хугацааны талаар тодорхой тусгасан байна.

Геологийн тогтоц ба ашигт малтмал бүлэг-т Тусгай зөвшөөрлийн талбайд өмнө нь хийсэн геологийн судалгааны болон эрэл, хайгуулын ажлын үр дүнд тогтоосон хурдас чулуулгийн төрлүүд, тэдгээрийн тархалт, тогтоц, үүссэн нөхцөл, геологийн биетүүдийн тогтцын онцлог, илэрсэн ашигт малтмал, тэдгээрийн тархалт байршил, шинж чанар, эрлийн шалгуур, шинж тэмдгүүдийн талаар тодорхой бичсэн байна.

Эрэл, хайгуулын ажлын аргачлал бүлэг-т Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд хийхээр төлөвлөсөн эрэл, хайгуулын ажлын үе, шатууд тэдгээрт гүйцэтгэх хээрийн судалгаа, суурин боловсруулалт, лабораторийн шинжилгээний ажлын төрөл, хэмжээ сонгосон үндэслэл, тэдгээрийг гүйцэтгэх аргачлал, дарааллын талаар тодорхой тусгасан байна.

Төсвийн тооцооны бүлэг-т Эрэл, хайгуулын ажлын аргачлалын бүлэгт гүйцэтгэхээр сонгосон ажлын төрөл, хэмжээг үндэслэн, нэгжийн өртгийг бодитойгоор авч төсвийн нэгдсэн тооцоог төгрөгөөр илэрхийлэн тооцож *Маягт-1*-ийн дагуу нэгтгэсэн байна.

Хавсралт зураг: Геологи хайгуулын ажлын төлөвлөгөөнд Геологийн болон ашигт малтмалын зураг, Төслийн зургуудыг хавсралт байдлаар үйлдэж оруулна. Зургийн ачааллаас хамааруулан эдгээр зургуудыг тусад нь болон нэгтгэсэн байдлаар зохиож болно. Зургийн масштабыг эрэл, хайгуулын ажил гүйцэтгэх талбайн хэмжээ, рельефийн байдал, судалгааны ажлын үе шатаас хамааруулан оновчтой байдлаар сонгосон байна. Зургийн өнгө, тэмдэглэгээ, таних тэмдгүүд болон холбогдох бусад зүйлүүд нь геологийн зурагт тавьдаг шаардлагыг хангасан байна. Мөн төлөвлөгөөний бичвэрийн хэсэгт шаардлагатай бүдүүвч, зургуудыг оруулж болно.

5. Хурдас чулуулгийн стратиграфийн ангиллын бичлэгийг Монголын литостратиграфийн кодексын дагуу хийсэн байна.

6. Төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд зарцуулагдах зардлыг тооцсон байна.

7. Геологи хайгуулын ажлын төлөвлөгөөг зохиоход ашигласан тайлан, материалын нэрсийг зохих дарааллын дагуу жагсааж хавсаргана.

8. Геологи хайгуулын ажлын төлөвлөгөөний нүүр хуудсыг *Хавсралт-1* –д үзүүлсэн маягаар үйлдсэн байна.

9. Геологи хайгуулын ажлын төлөвлөгөөг боловсруулсан геологийн болон санхүүгийн холбогдох ажилтнууд нь гарын үсгээ зурж, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн удирдлага нь баталгаажуулсан байна.

10. Хэрэв хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийнхээ 9 дүгээр сарын 31-нээс хойш хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр авсан бол хайгуулын ажлын төлөвлөгөөг дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн төлөвлөж болох ба хайгуулын ажлын зардлын доод хэмжээг Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх хэсэгт заасан хугацаагаар тооцно.

11. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлж байгаа төлөвлөгөө нь энэ заавар, шаардлагыг хангахгүй бол албан тоотоор тухайн аж ахуйн нэгжид буцаана.

12. Цөмийн материалын хэлтсийн төлөвлөгөө хүлээн авч байгаа мэргэжилтэн нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлж байгаа хайгуулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэмжээнд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, гүйцэтгэх гэж байгаа арга аргачлалд зөвлөмж чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавина.

13. Төлөвлөгөөнд холбогдох мэргэжилтнүүдийн гарын үсэг зурагдаж баталгаажуулсаны дараа хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагад албан тоотоор ирүүлснээр тухайн жилийн төлөвлөгөөг хүлээн авсанд тооцно.

“ ” ХХК

Зохиогч

**АЙМГИЙН СУМЫН НУТАГ ДАХЬ
ТАЛБАЙД
ОНД ХИЙХ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тусгай зөвшөөрлийн дугаар Х

Ашигт малтмалын төрөл

Судалгааны үе, шат

Хянаж, хүлээн авсан: ЦЭГ-ын ЦМХ-ийн мэргэжилтэн

..... /

.....онысарын..... өдөр

МХЕГ-ын БОГУУХУА-ны

ахлах байцаагч /

.....онысарын..... өдөр

.....ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙД
ОНД ГҮЙЦЭТГЭХ ХАЙГУУЛЫН АЖЛЫН
 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ, ТӨСВИЙН НЭГТГЭЛ

д/ д	Ажлын төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	дэх жилд		 дэх жилд	
				Ажлын хэмжээ	Төсөв ₮	Ажлын хэмжээ	Төсөв ₮
1	Бэлтгэл ажил						
	-Төлөвлөгөө зохиох	х/ө					
	-АСФЗ-ийн тайлал	кв.км					
	-						
2	Талбайн зураглал	кв.км					
3	Эрлийн маршрут	т.км					
4	Талбайн сорьцлолт						
	Геохими:	сорьц					
	-						
	Шлихийн сорьцлолт	сорьц					
5	Геофизикийн ажил:						
	-	Физ.цэг					
	-						
6	Уулын ажил:						
	- суваг малталт	куб.м					
	- шурф эвтрэлт	т.м					
	-						
	-булалт	куб.м					
7	Өрөмдлөг:						
	-Баганат	т.м					
	-Цохилтот	т.м					
	-						
8	Сорьцлолт						
	-	ш					
	-	ш					
9	Лабораторийн ажил:						
	-						
	-						
10	Тээвэр:						
11	БОНС-ын зардал						
12	Топогеодезийн ажил:						
13	Суурин боловсруулалт	х/ө					
14	гэх мэт бусад						
	Дүн						
	1 га талбайд ногдох төлөвлөсөн зардал						

Тусгай зөвшөөрөл эзэмшигч:.....ХХК-ийн

Тамга

Захирал

Геологич.....

Санхүүч:.....